

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

- а. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
б. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

- Дээд палеолитын үед гарсан дэвшил аль нь вэ? (1 оноо)
 А. Хадны зураг В. Гал
 С. Нум сум Д. Үйлдвэрлэх аж ахуй Е. Хүрэл зэвсэг
- Мезолитын үед багаж зэвсэгт ямар дэвшил гарсан бэ? (2 оноо)
 А. Зэсийг хорголжин тугалгатай хольж хүрэл боловсруулж эхэлсэн.
 В. Үлдэц, цуулдас гаргах аргаар чулуун зэвсэг хийх болсон.
 С. Модны уян харимхай чанарыг ашиглан нум сум зохион бүтээсэн.
 Д. Шавар ваар, сав хийж хэрэглэх болсон.
 Е. Үзүүр мэсийг ишинд бэхэлж жад хийх болсон.
- Монгол нутагт үйлдвэрлэх аж ахуй үүссэнээр хүмүүс гөрөөчлөн тэнүүчлэх нь цөөрч, суурин хэв маягийн амьдралд шилжиж байсныг гэрчлэх, нүх ухаг байгуулсан, өрхөөр нь орж гардаг, модон багана, шалтай газар сууцууд хаанаас олдсон бэ? (1 оноо)
 А. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул
 В. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
 С. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам
 Д. Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагбулаг
 Е. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
- Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 Монгол орны зүүн, төв нутгаар голлон тархсан хүрэл, түрүү төмрийн үеийн оршуулгын байгууламжийг гэнэ. (1 оноо)
 А. Чемурчекийн соёл В. Буган хөшөө
 С. Хадны зураг Д. Хиргисүүр Е. Дөрвөлжин булш
- Монгол нутагт эртний хүмүүс хүрлийн үе, түрүү төмрийн үеэс өөр хоорондоо зөрчилдөх болжээ. Зөрчилдөх болсон гол шалтгааныг тодорхойлно уу. (1 оноо)
 А. Торгоны замд нөлөөллөө тогтоох өрсөлдөөн нэмэгдсэн.
 В. Хэл ярианд суурилсан харилцаа хөгжсөнөөр хүмүүс мэдлэгээ солилцох болсон.
 С. Газар тариалан эрхлэгчдийн тоо нэмэгдэж үржил шимтэй нутгийн хэмжээ багассан.
 Д. Хүн ам, малын тоо нэмэгдэж бэлчээр, гөрөөлөх нутгийн хүрэлцээ багассан.
 Е. Зөөлөн чийглэг уур амьсгалтай болсноор тариалан эрхлэгчдийн тоо нэмэгдсэн.
- Хүннү гүрний түүхэнд холбогдох үйл явдлуудыг онтой нь зөв харгалзуулна уу. (1 оноо)
 1. Хүннү гүрэн байгуулагдав. а. НТ 93 он
 2. Хүннү гүрэн умард, өмнөд хоёр хэсэгт хуваагдав. б. НТӨ 209 он
 3. Хүннү гүрэн мөхөв. в. НТ 48 он
 А. 1c2a3b В. 1a2b3c С. 1b2c3a Д. 1b2a3c Е. 1c2b3a
- Хүннүгийн баруун өмнө, Хятадаас чанх баруун тийш 10 000 ли /5000 км/ газарт Даюань /Дундад азийн Ферганы хөндий/ бий. 1 ли хэдэн км-тэй тэнцэх вэ? (2 оноо)
 А. 5000 км В. 0.5 км С. 15 000 км Д. 2 км Е. 0.05 км
- Монгол нутагт оршиж байсан Түрэг угсааны улсыг олно уу. (1 оноо)
 А. Сяньби улс В. Уйгур улс
 С. Хүннү улс Д. Жужан улс Е. Хятан улс



9. “Эмэгтэйчүүд нь хатгамал хатгана, эсгий оёж ширдэг хийнэ. Эрэгтэйчүүд нь нум сум, эмээл хазаар хийдэг” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар аж ахуйн талаар өгүүлж байна вэ? (1 оноо)
- | | | |
|----------------|-------------------|----------------------|
| A. Ан гөрөө | B. Газар тариалан | E. Худалдаа, арилжаа |
| C. Мал аж ахуй | D. Гар урлал | |
10. “Хань (Хятад)-ийн торго дурданг өвс бутан дундуур чирэн явав. Хувцас хунар цөм урагдан салбарчээ. Арьсан дээл хувцас шиг бөх биш юм. Хань-ийн хоол идээ бүгдийг хаяв. Айраг хурууд шиг шимтэй бус гэдгийг үзэв” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санаа илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү улсын хоол хүнс, эдийн соёл нь Хань улсынхаас илүү зохимжтой байсан.
 - B. Хань улсын хоол хүнс, эдийн соёл нь Хүннүгийнхээс илүү зохимжтой байсан.
 - C. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.
 - D. Хүннүчүүд бүх дээл хувцсаа торгоор хийдэг байсан.
 - E. Хань улс Хүннү нартай адил айраг хурууд хүнсэндээ хэрэглэх болсон.
11. Хүннү нарын олонх нь ямар шашин, шүтлэгтэй байсан бэ? (1 оноо)
- | | | |
|------------------|--------------------|-------------------|
| A. Исламын шашин | B. Бурхны шашин | E. Манихейн шашин |
| C. Бөөгийн шашин | D. Загалмайн шашин | |
12. Хүннүгийн язгууртны булшнаас /Архангай аймгийн Өндөр-Улаан сум/ Ромын шилэн аяга олдсон нь юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү гүрний шаньюй, Ромын эзэнт гүрэнд айлчилж байсан.
 - B. Хүннү гүрэн, Ромын эзэнт улсыг эзлэн захирч байсан.
 - C. Хүннү гүрэн, Ромын эзэнт улстай шууд хиллэдэг байсан.
 - D. Ромын шилэн аяга Хүннү нараас үүсэлтэй
 - E. Хүннү гүрэн өрнийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаатай байсан.
13. X-XII зууны ихэнх Монгол аймгууд ямар шашин шүтлэгтэй байсан бэ? (1 оноо)
- | | | |
|------------------|--------------------|-------------------|
| A. Буддын шашин | B. Загалмайн шашин | E. Манихейн шашин |
| C. Исламын шашин | D. Бөөгийн шашин | |
14. 1130 онд Хабул хан Монгол улсыг байгуулжээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолно уу. (2 оноо)
- | | | |
|----------------------|-----------------------|--------------------|
| A. XII зууны I хагас | B. XII зууны II хагас | E. X зууны I хагас |
| C. XI зууны I хагас | D. XI зууны II хагас | |
15. “Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр гурван ямхаас давахгүй” гэсэн сурвалжийн мэдээг ашиглан татар хүний өндрийг тооцоолон олно уу. /нэг тохой 35 см орчим, ямх-3.2 см/ (2 оноо)
- | | | |
|-------------------|-------------------|-------------------|
| A. 171.4-174.6 см | B. 175-178.2 см | E. 176.4-179.6 см |
| C. 156.4-159.6 см | D. 181.4-184.6 см | |
16. Их Монгол улс 1260-1264 онд нэгэн зэрэг хоёр хаантай байсан. Тэдгээр хаадыг олно уу. (1 оноо)
- | | | |
|---------------------|-------------------|--------------------|
| A. Өгэдэй, Тулуй | B. Гүюг, Мөнх | E. Хүлэгү, Аригбөх |
| C. Хубилай, Аригбөх | D. Хубилай, Хайду | |
17. Юань улс хүн амаа дөрвөн зэрэгт хуваажээ. Тэргүүн зэрэгт ямар хүн хамаарах вэ? (1 оноо)
- | | | |
|------------------|---------------------|----------------------|
| A. Зүрчид, Хятан | B. Монгол хүн | E. Умард хятадын хүн |
| C. Нанхиад хүн | D. Өнгөт нүдтэн хүн | |



18. Цагадайн улсын газар нутгийг зөв тодорхойлно уу. (1 оноо)
 А. Дорно зүг Эрчис мөрөн, өрнө зүгт Дунай мөрний доод урсгал, өмнө зүгт Кавказын нуруу, хойд зүгт Ижил мөрөн хүртэл
 В. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу хуучин Хар Хятаны нутаг
 С. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Сирийн хойд хэсэг Афганистаны баруун хэсэг
 D. Монгол, Төвөд, Солонгос, Хятадын нутаг
 E. Өнөөгийн Иран, Ирак, Солонгос, Хятадын нутаг
19. Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томъёог ашиглаарай. **(X=M-M/33+622)**
 Зоосны нүүрэн талд “Аугаа их Султан Тогтох” нөгөө талд бурхны авралд Сарай хотод 710 онд цутгав” гэжээ. Хижрийн тооллын 710 оныг аргын тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)
 А. 1365 он В. 55 он С. 1311 он D. 1332 он E. 655 он
20. Төгстөмөр хааны төр барьсан он аль нь вэ?. (1 оноо)
 А. 1400-1402 он В. 1370-1378 он
 С. 1393-1399 он D. 1378-1388 он E. 1403-1412 он
21. Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын зүүн гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу (2 оноо)
 1. Ордос 2. Халх 3. Урианхай 4. Түмэд 5. Юншээбүү 6. Цахар
 А. 4,5,6 В. 1,4,5 С. 2,4,5 D. 1,2,3 E. 2,3,6
22. Мин улс Монголчуудтай худалдаа хийхдээ баримталдаг “адуун засгийн бодлого” нь ямар зорилготой байсан бэ? (2 оноо)
 А. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн бүтцийг алдагдуулах
 В. Газар тариалангийн салбарт адууны хүчийг ихээр ашиглах
 С. Худалдааны салбарт адуу ашиглан бараа таваар тээвэрлэх
 D. Мин улс барууны улс орнуудтай адуугаар худалдаа хийх
 E. Монголчуудад адуугаараа хятад бараа худалдан авах нь ашигтай байсан
23. Хөх нуур, Төвөдийг эзэлж, Хошууд улсыг байгуулсан түүхэн зүтгэлтэн аль нь вэ? (1 оноо)
 А. Цогт Тайж В. Лигдэн хаан
 С. Галдан бошгот D. Гүүш хан Төрбайх E. Шолой Уваш
24. Тод үсгийг хэн зохиосон бэ? (1 оноо)
 А. Аюуш гүүш В. Өндөр гэгээн Занабазар
 С. Зая бандида Намхайжамц D. Пагва лам E. Агваан лам
25. Түмэдийн Алтан ханы шашны цааз хэрэгжсэнээр монголчуудын ёс заншилд ямар өөрчлөлт гарсан бэ? (2 оноо)
 А. Хаад ноёд асар том гэр тэрэг хэрэглэх болсон.
 В. Сарын гурван бацгийн /мацаг/ өдөрт малын амь таслах буюу шувуу авлахыг тэвчих болсон.
 С. Хүн нас барвал чинээ чинээгээр тэмээ, морийг алж, хойлго хийх болсон.
 D. Монголчууд хүрээний зохион байгуулалтаар нүүдэллэх болсон.
 E. Эрчүүд тайван цагт мал аж ахуйгаа эрхлэн, дайн байлдааны үед бүгд цэрэг болдог.



26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Шашны цаазаар лам нарын эрх, дархыг хуульчлан баталж, дэмжих бодлого явуулсан
 В. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилготой байсан
 С. Бөөгийн хойлголох ёсыг халж хүн нас барахад амьтны амь таслахыг хориглосон нь ард олны сэтгэлд нийцсэн
 D. Монголчуудыг шашиндаа оруулснаар нөлөөнийхөө хүрээг тэлэх, Төв Азид өөрийн улсын эзлэх байр суурийг өсгөх зорилготой байсан
 E. Шашин дэлгэрэхэд улсаас эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн
27. Зүүнгар улс Манжид хэзээ эзлэгдсэн бэ? (1 оноо)
 А. 1688 он В. 1636 он С. 1721 он D. 1691 он E. 1755 он
28. 1636 оны Мүгдэнгийн чуулганаар Өвөр Монголын ноёд ямар асуудлыг шийдвэрлэсэн бэ? (2 оноо)
 А. Өвөр Монголын 16 аймгийн ноёд Манж улсын хааныг эзэн хаанаа хэмээн зөвшөөрөв.
 В. Халхын ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцэв.
 С.Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв.
 D. “Монгол-Ойрадын Их цааз” -ыг батлав.
 E. Торгуудын Хо өрлөг, Дөрвөдийн Далай тайш нар харьяатаа авч баруун тийш нүүдэллэв.
29. 1727 оны Буурын гэрээгээр Оросын хаант улсын мэдэлд бүрэн орсон монголчууд аль нь вэ? (1 оноо)
 А. Буриад Монгол В. Халимаг
 С. Өвөр Монгол D. Хотгойд E. Халх Монгол
30. 1617 онд Авга хар ууланд Очир Цагаан хотыг хэн байгуулсан бэ? (1 оноо)
 А. Цогт тайж В. Алтан хан
 С. Өндөр гэгээн Занабазар D. Хубилай хаан E. Лигдэн хаан
31. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу. (2 оноо)
 А. Монголын их хааны сүр хүч буурч, эрх мэдлийн хуваарилалт алдагдсан.
 В. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн.
 С. Манж нар монголчуудыг их цэргээр удаа дараа довтолсон.
 D. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн.
 E. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан.
32. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 Ихэтуаны бослогыг даруулахаар Халх Монголоос татсан 2000 монгол цэрэг 1900 онд Улиастайд удирдлагаар бослого дэгдэв. (1 оноо)
 А. Тогтох тайж В. Цогдалай С. Чингүнжав
 D. Онолт E. Энхтайван
33. Тогтох тайж ямар шалтгаанаас болж хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, өрийн дансыг устгасан бэ? (2 оноо)
 А. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдсанаас болсон.
 В. Бүрнэ, Лувсан нар 1675 онд Манжийн ноёрхлыг эсэргүүцэн босож тэмцээд амь үрэгдсэн.
 С.1756 онд Чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авснаас болсон.
 D. Өвөр Монголд Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг хэрээс хэтэрсэн.
 E. Зүүнгарын монголчуудыг олон арван мянгаар нь хядсан.



34. Монголчууд Манжийн эрхшээлээс салж тусгаар тогтнолоо хэзээ сэргээн тунхагласан бэ? (1 оноо)
 А. 1911.12.01 В. 1911.11.30
 С. 1911.12.29 Д. 1911.12.04 Е. 1911.12.03
35. Монголчууд Улиастайг Манжийн эрхшээлээс хэзээ чөлөөлсөн бэ? (1 оноо)
 А. 1912.2 сард В. 1912.8 сард
 С. 1912.1 сард Д. 1914.2 сард Е. 1915.6 сард
36. Хужирбуланд цэргийн сургууль хэзээ байгуулсан бэ? (1 оноо)
 А. 1913 он В. 1912 он С. 1914 он Д. 1918 он Е. 1915 он
37. 1916 онд “Улсын хөрөнгийг захирах газар”-ыг байгуулжээ. Энэ Олноо өргөгдсөний хэддүгээр он бэ? (2 оноо)
 А. 5 дугаар он В. 6 дугаар он
 С. 7 дугаар он Д. 16 дугаар он Е. 17 дугаар он
38. Ардын Түр Засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (2 оноо)
 А. Америкийн консулыг Монголд суулгах хүсэлт гаргасан.
 В. “Бага болзоот” хэмээх цаасан мөнгө гаргасан.
 С. Гадаад бодлогодоо анхаарч Монгол, Дундад иргэн улсын хооронд АНУ-аар зуучлуулах хүсэлт гаргасан.
 Д. Цагаантны цэргийг хөөн зайлуулахын тулд улаан цэргийн ангийг Монголд оруулах хүсэлтийг ЗОУ-д тавьсан.
 Е. АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан.
39. Монгол улсын хөгжлийн талаарх Д.Бодоогийн үзэл баримтлал аль нь вэ? (1 оноо)
 А. Уламжлалт хэмжээгүй эрхт хаант засаглалтай байх
 В. Монголд бүгд найрамдах засаг тогтоох, хүн төрөлхтний туулж ирсэн жам ёсны дагуу, шат дараалан хөгжих ёстой.
 С. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах
 Д. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих
 Е. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой.
40. Ардын засгийн газраас дотоод байдлаа бэхжүүлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аль нь вэ? (2 оноо)
 А. Эзэн, хамжлагын харилцааг халах шийдвэр гаргасан
 В. Дэлхийн олон улсад хандан хэмжээт цаазат хаант Монгол улс байгуулагдсаныг зарлан мэдэгдсэн.
 С. С.Данзан тэргүүтэй Монголын төлөөлөгчид Москвад айлчилсан.
 Д. 1921 оны 11 сарын 5 нд ЗОУ-тай найрамдлын гэрээ байгуулсан.
 Е. Дундад иргэн улс цэрэг-улс төрийн дарамт шахалт үзүүлж байсан үед ЗОУ-ыг түшиглэсэн.
41. Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа хэзээ баталсан бэ? (1 оноо)
 А. 1960.07.06 В. 1924.06.07
 С. 1940.06.30 Д. 1924.11.26 Е. 1992.01.13
42. Анхдугаар Үндсэн хуулиар улс төрийн эрхээ хасуулсан хүмүүс аль нь вэ? (1 оноо)
 А. Бусдын хөдөлмөрийг үл мөлжигч 18 нас хүрсэн иргэн бүр
 В. Жирийн ард С. Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад
 Д. Үгээгүй ядуу ард Е. Малчид



43. Шинэ эргэлтийн бодлогын үр дүн аль нь вэ? (2 оноо)
А. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлсэн.
В. Ард түмний шүтэх, бишрэх эрх чөлөөг сэргээж, лам нарыг албадан хар болгохоо зогсоосон.
С. Нөхөрлөл, коммуна, артель, нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зуугаар нь байгуулсан.
D. Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгон хувийн худалдааг хавчих болсон.
E. Улс орныг удирдах хэрэгт намын үүрэг нэмэгдсэн
44. Дэлхийн II дайн ямар үйл явдлаар дууссан бэ? (1 оноо)
А. 1945 оны 8 сарын 10-нд БНМАУ Японд дайн зарласан.
В. 1945 оны 5 сарын 9-нд Нацист Герман бууж өгсөн.
С. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ, Японд дайн зарласан.
D. 1945 оны 9 сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурсан.
E. 1945 оны 2 сард Ялтад гурван их гүрний уулзалт болсон
45. Соёлын довтолгоо хэдэн оноос эхэлсэн бэ? (1 оноо)
А. 1961 он В. 1956 он С. 1966 он D. 1981 он E. 1959 он
46. Монголын урлаг, уран сайхны хөгжилд аль нь хамаарах вэ? (1 оноо)
А. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан.
В. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн.
С. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан.
D. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон.
E. Малын үүлдэр угсааг сайжруулах, элдэв өвчнийг анагаах чиглэлээр судалгаа хийсний үр дүнд Хангай, Байдраг зэрэг шинэ үүлдэр гаргасан.
47. БНМАУ 1965 онд Франц улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой вэ? (2 оноо)
А. 61 жилийн ой В. 59 жилийн ой
С. 58 жилийн ой D. 57 жилийн ой E. 50 жилийн ой
48. Дараах улсуудаас капиталист системд хамаарч байсныг олно уу. (2 оноо)
А. Чехословак В. Зүүн Герман
С. Баруун Герман D. Хятад E. Умард Солонгос
49. Ховдын Багшийн Дээд сургуулийн хэсэг залуус, багш, оюутнууд хэзээ улс төрийн жагсаал цуглаан зохион байгуулсан бэ? (1 оноо)
А. 1989.12.10 В. 1989.12.07
С. 1990.01.21 D. 1990.02.18 E. 1990.03.07
50. Аль түүхэн үйл явдлаар БНМАУ-д нэг намын ноёрхол эцэс болсон бэ? (2 оноо)
А. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
В. 1990 оны 3 сарын 12-14 нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
С. 1990 оны 3 сарын 9-ний орой нам, төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио, телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
D. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгосноор
E. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар



51. Монгол улс шинэ Үндсэн хуулиа хэзээ баталсан бэ? (1 оноо)
А. 1991 оны 1-р сарын 31
В. 1990 оны 4-р сарын 27
С. 1990 оны 7-р сарын 22
D. 1996 оны 6-р сарын 30
E. 1992 оны 1-р сарын 13
52. Шинэ үндсэн хуулиар гүйцэтгэх эрх мэдлийг төрийн ямар институт хэрэгжүүлэх болсон бэ? (1 оноо)
А. Засгийн газар
B. Улсын их хурал
C. Улсын дээд шүүх
D. Үндсэн хуулийн цэц
E. Ардын их хурал
53. Монголын төр 1996 онд ард түмнээсээ уучлал гуйж, 9 сарын 10-ыг ямар тэмдэглэлт өдөр болгосон бэ? (1 оноо)
А. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр
B. Монгол бахархлын өдөр
C. Эх орончдын өдөр
D. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр
E. Олон улсын хүний эрхийн өдөр
54. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг илэрхийлэх баримт аль нь вэ? (2 оноо)
А. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
B. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” баталсан.
C. Төрт ёсны уламжлалт 9 хөлт цагаан тугаа хүндэтгэн залсан.
D. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
E. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.
55. Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт юу вэ? (1 оноо)
А. НҮБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
B. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
C. Өрнө, дорнын хөгжингүй орнуудтай найрсаг харилцаатай байх
D. Азийн улсуудтай найрсаг харилцаатай байх
E. “Гуравдагч хөрш” улсуудтай найрсаг харилцаатай байх
56. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү
Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж төрөө бэхжүүлж, улс төрийн тогтвортой байдлыг хангах нь.....-ын үндэс мөн. (1 оноо)
А. Мэдээллийн аюулгүй байдал
B. Хүний аюулгүй байдал
C. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
D. Дотоод аюулгүй байдал
E. Эдийн засгийн аюулгүй байдал



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
 б. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлт болон дурсгалуудыг хамрах үетэй нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|-------------------|---------------------------------|
| а. Гал | 1. Неолит |
| б. Нум сум | 2. Хүрлийн үе, түрүү төмрийн үе |
| с. Хэл яриа | 3. Дээд палеолит |
| д. Шавар ваар | 4. Доод палеолит |
| е. Нарийн гол 17Б | 5. Мезолит |
| ф. Буган хөшөө | 6. Дунд палеолит |

2.2. Чингис хаантай холбогдох үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---|------------|
| а. Чингис хаан Татарыг мөхөөв. | 1. 1225 он |
| б. Чингис хаан Наху гүний тулалдаанаар Найманыг мөхөөв. | 2. 1202 он |
| с. Их Монгол улсыг тунхаглан зарлав. | 3. 1211 он |
| д. Чингис хаан Алтан улсыг довтлов. | 4. 1204 он |
| е. Хорезм улсыг бүрэн эзлээд эх нутагтаа эргэж ирэв. | 5. 1227 он |
| ф. Тангуд улсыг дайлж бүр мөсөн мөхөөв. | 6. 1206 он |

2.3. Түүхэн нэр томъёонуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------|---------------|
| а. Халх Монгол | 1. Шолой Уваш |
| б. Өвөр Монгол | 2. Ордос |
| с. Арын долоон отог | 3. Цорос |
| д. Манж | 4. Засагт хан |
| е. Дөрвөн Ойрад | 5. Гэрсэнз |
| ф. Хотгойд | 6. Нурхач |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/ (6 оноо)

- | | |
|---|-------------------------|
| а. Барон Унгерн Монголын зүүн хилээр орж ирэв. | 1. 1921 оны 7 сарын 8 |
| б. Зүүн хүрээ, Консулын дэнжийн 2 бүлэг хамтран хуралдав. | 2. 1921 оны 3 сарын 18 |
| с. Улаан цэрэг, Ардын журамт цэргийн хамт Хиагтыг чөлөөлөв. | 3. 1919 оны 11 сарын 17 |
| д. Барон Унгерн цэргээ авч Нийслэл хүрээнээс гарав. | 4. 1921 оны 5 сард |
| е. Ардын журамт цэргийн гол хүч Нийслэл хүрээнд орж ирэв. | 5. 1920 оны 10 сарын 2 |
| ф. Ардын засгийн газар байгуулагдав. | 6. 1921 оны 7 сарын 10 |
| | 7. 1921 оны 3 сарын 17 |
| | 8. 1921 оны 7 сарын 6 |

